



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/45

Хөхбүрд

“Эрүүл бэлчээр-Эрсдэлгүй малчны хот”
уриатай сэг зэм ариутгал, халвдаргүйтгэлийн
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2, 7.3.3 дахь заалт, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын А/206 дугаар тоот Захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны сэг, зэм устгал, халдваргүйтгэлийн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Булаг шанд, гол нуурын орчинд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэм устгалыг мал, амьтны шилжилт хөдөлгөөн, бэлчээрээс хол газарт тодорхой устгалын цэг байгуулж, устгаж булшлан орчны ариутгал халдваргүйтгэлийг хийж, тэмдэгжүүлэн солбилцолыг авч ажиллахыг Багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдэд хариуцуулсугай.

3. Дээрх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж хагас, бүтэн жилээр тайлагнахыг Мал эмнэлгийн тасаг (Ж.Ёндонпил), Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Мал, амьтны сэг зэм устгах, орчны ариутгал халвдаргүйтгэлийн ажилд шаардагдах ариутгалын бодис, уусмал, халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл, хүн хүч, тээврийн хэрэгсэл болон шаардлагатай бусад зардлыг гамшгийн зардлаас санхүүжүүлэхийг нятлан бодогч (Л.Алимаа)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Ганцоож)-д даалгасугай.

ДАРГА Ж.ХАТАНБААТАР



642301067

Сумын Засаг даргын 2023 оны 04 сарын 24
өдрийн А/... дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт

“Эрүүл бэлчээр-Эрсдэлгүй малчны хот”
уриатай сэг зэм ариутгал, халвдаргүйтгэлийн
ажил зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах штабын бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: М.Жавзансүрэн – ЗДТГ-ын дарга

- Ж.Ёндонпил – Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч
- Ж.Жамъяндагва - Мал эмнэлгийн тасгийн Улсын
байцаагчыг түр орлон гүйцэтгэгч
- Т. Цэцэгсайхан–Мандалхайрхан 1-р багийн Засаг дарга
- С.Энх-Амгалан –Уранхайрхан 2-р багийн Засаг дарга
- М.Сэр-Од –Асгамба 3-р багийн Засаг дарга
- Б.Дагдансүрэн –Мэргэн 4-р багийн Засаг дарга
- Л.Гүндцамба – ХААТ-ын дарга
- Н.Ганбат- Байгаль хамгаалагч
- Д.Зоригт- ‘ШМДЗ’ ххк малын эмч
- Б.Лхагвасүрэн- ‘Хишиг тайжийн’ овоо ххк малын эмч
- Ц.Дандар- ‘Эрдэнэт сүргийн’ хишиг ххк малыг эмч